

ХӨТӨЛБӨРИЙН ЕРӨНХИЙ ХОРООНЫ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2026 оны 02 дугаар сарын 05

№05

Улаанбаатар хот

Хөтөлбөрийн ерөнхий хорооны хурал 2026 оны 02 дугаар сарын 05-ны өдөр 10:00 цагаас 85,7 хувийн ирцтэй эхэлж, ХЕХ-ны дарга Н.Эрдэнэхүү удирдан явуулав.

Хуралд:

Хөтөлбөрийн ерөнхий хорооны дарга

1. Н.Эрдэнэхүү Сургалт, оюутны асуудал эрхэлсэн проректор

Нарийн бичгийн дарга

2. М.Эрдэнэтуяа Сургалтын бодлого, зохицуулалтын албаны дарга

Гишүүд

3. И.Цэрэн-Онолт АТС-ийн захирлын үүрэг гүйцэтгэгч
4. Ц.Цэцэгмаа ГХС-ийн хэрэглээний хэл шинжлэлийн тэнхимийн профессор
5. Д.Ариунболор НБХ-ийн профессор
6. Ц.Балжинням ХШУС-ийн сургалт, чанарын албаны дарга
7. П.Ууганбаяр МХТС-ийн сургалт, чанарын албаны дарга
8. Н.Одонтуяа ДаТС-ийн сургалт, чанарын албаны дарга
9. Ш.Цоож МИТС-ийн механик инженерчлэлийн тэнхимийн дэд профессор
10. Я.Наранцэцэг АТС-ийн профессор
11. Ц.Энхбаатар ГХС-ийн захирал
12. Ч.Алдармаа ХШУС-ийн физикийн тэнхимийн профессор (ӨмТДС-ийн төлөөлөл, зөвшилцсөнөөр)
13. Д.Үлэмж ЭХИС-ийн эрдэмтэн нарийн бичгийн дарга
14. С.Туяа НХС-ийн сургалт, чанарын албаны дарга
15. Ж.Алтанцэцэг БАС-ийн барилгын инженерчлэлийн тэнхимийн дэд профессор
16. М.Банзрагч МС-ийн сургалт, чанарын албаны дарга
17. Г.Өлзийсайхан ГУУС-ийн сургалт, чанарын албаны дарга
18. Г.Ариунтөгс Сургалтын бодлого, зохицуулалтын албаны ахлах мэргэжилтэн

нар оролцов.

Хэлэлцэх асуудлууд:

1. “Хөргөлтийн технологи ба кондиционерийн систем” бакалаврын хөтөлбөрөөр БНХАУ-ын Шанхайн ШУТИС-тай (2+2) хамтарсан хөтөлбөр нээх тухай (ЭХИС)
2. “071302.Эрчим хүчний ухаалаг сүлжээ ба систем” бакалаврын хөтөлбөр нээх тухай (ЭХИС)
3. Доктор хөтөлбөрийн индекс шинээр батлуулах хүсэлт гаргах тухай (ЭХИС)-Эмнэлгийн тоног төхөөрөмжийн ашиглалт
4. “104101.Тээврийн үйлчилгээ” бакалаврын хөтөлбөр нээх тухай (МИТС)
5. Магистрын хөтөлбөрийн нэр, индекс шинээр батлуулах хүсэлт гаргах тухай (МС)
 - Инженерчлэлийн менежмент
 - Спортын менежмент
 - Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн менежмент
6. “061301. Компьютерын ухаан” бакалаврын хөтөлбөрөөр БНСУ-ын Үндэсний нээлттэй их сургуультай (2+1+1) хамтарсан хөтөлбөр нээх тухай (МХТС)
7. Бусад асуудал

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

1. ЭХИС-д “Хөргөлтийн технологи ба кондиционерийн систем” бакалаврын хөтөлбөрөөр БНХАУ-ын Шанхайн ШУТИС-тай (2+2) хамтарсан хөтөлбөр нээх тухай асуудлыг томилогдсон шинжээч, хөтөлбөрийн ерөнхий хорооны гишүүдийн зөвлөмжийн дагуу зарим бүрэлдэхүүн хэсэгт сайжруулалтыг хийн хөтөлбөрийг батлуулан, хэрэгжүүлэхийг гишүүдийн 100 хувийн саналаар дэмжлээ.
2. ЭХИС-д “Эрчим хүчний ухаалаг сүлжээ ба систем” бакалаврын хөтөлбөр нээх тухай асуудлыг томилогдсон шинжээч, хөтөлбөрийн ерөнхий хорооны гишүүдийн зөвлөмжийн дагуу зарим бүрэлдэхүүн хэсэгт сайжруулалтыг (ШУТИС-ийн бакалаврын цөм хөтөлбөрт тавигдах нийтлэг шаардлагад нийцүүлэн сургалтын төлөвлөгөөг сайжруулах, багшийн судалгааг нарийвчлан гаргах гэх мэт) хийсэн тохиолдолд урьдчилсан магадлан итгэмжлэл хийлгэхээр БМИҮЗ-д хүсэлт хүргүүлэхийг гишүүдийн 88.8 хувийн саналаар дэмжлээ.
3. ЭХИС-аас Эмнэлгийн тоног төхөөрөмжийн ашиглалт хөтөлбөрт докторын түвшин нэмүүлэх саналыг хөтөлбөрийн ерөнхий хорооны гишүүдийн саналыг тусган, АШУҮИС-ийн холбогдох бүрэлдэхүүн сургууль, тэнхимд танилцуулан санал авах, МХТС, МИТС, АТС-ийн хөтөлбөрийн хороодоор хэлэлцүүлж, саналыг тусган сайжруулалт хийж, дахин хэлэлцүүлэхээр буцаав.
4. МИТС-д “Тээврийн үйлчилгээ” бакалаврын хөтөлбөр нээх тухай асуудлыг хэрэгжүүлэх чиглэлийг тодорхой болгон, санал болгосон 2 хувилбарын аль нэгийг сонгон дахин шинээр боловсруулах чиглэл өгөн буцаав.
 - (a) “Инженерчлэл, эдийн засаг(078814)” хөтөлбөрт чиглүүлэн бүрэлдэхүүн сургуулиудын хөтөлбөрийн (БАС, МИТС, МХТС, ЭХИС) уялдааг ханган шинээр боловсруулах.
 - (b) “Тээврийн үйлчилгээ” буюу үйлчилгээ чиглэлд хамаарах агуулгаар хөтөлбөрийг дахин шинэчилж боловсруулах.
5. МС-ийн “Спортын менежмент” магистрын хөтөлбөрийн нэр, индекс шинээр батлуулах хүсэлтийг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэхийг гишүүдийн 100 хувийн саналаар дэмжлээ.
6. Бусад асуудал
 - Ахисан түвшний болон бакалаврын хөтөлбөрийг цаашид хэрхэн зохион байгуулж хэрэгжүүлэх талаар (шинээр нээх, зарим хөтөлбөрийг хаах, түр зогсоох гэх мэт) асуудлыг бэлтгэн танилцуулахыг СБЗА-ны дарга, АТС-ийн захирал нарт даалгав.